



ТАНАЙ СУМЫГ ЗОРИН ИРЭХ ИРГЭДЭД ЯМАР БОЛОМЖ НӨХЦӨЛ ОЛГОХ ВЭ?

Манай сум нь “Төмс хүсний ногоо, жимс жимсгэнэ үйлдвэрлэлээр стратегийн бүс нутаг” болох зорилго тавьж дараах гол зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгож, хэрэглэгч сумаас үйлдвэрлэгч сум болох суурь нөхцөлийг бүрдүүлэх
- Ажлын байрыг нэмэгдүүлж, ажиллах хүчний байршлыг хүн амын суурьшил, газар нутгийн зохион байгуулалт, эдийн засгийн бүтэцтэй уялдуулан зөв байршуулах
- Нийгмийн дэд бүтэц, Орон сууцны хангамжийг дээшлүүлэх

Манай сум төр, төсвийн 5 байгууллагатай ба сумын хэмжээнд нийт сул 12 ажлын байр нээлттэй байна.

Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд жил бүр төв зам дагуу 80-100 иргэдэд газар өмчлүүлэхээр төлөвлөдөг. Мөн сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд тариалангийн зориулалтаар таван байршилд газар олгохоор төлөвлөсөн бөгөөд тус төлөвлөгөөний дагуу газар олголт хийгдэнэ.

2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 153 байршилд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар гэр, орон сууц хашааны газар олгохоор төлөвлөсөн.



НЭЭЛТТЭЙ СЭЛЭНГЭ



ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

СУМ ОРОН НУТГИЙН ОНЦЛОГ? ДАВУУ ТАЛ:

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сум нь анх 1674 онд Түшээт хан аймгийн Шибутай Хатанбаатарын хошуу нэртэй байгуулагдсан бөгөөд БНМАУ-ын шинэ үндсэн хуулийн дагуу 1924 онд орон нутгийн засаг захиргааны шинэчилсэн зохион байгуулалтаар Богд хан уулын Зүүнбүрэн хан уулын хошуу хэмээн нэрлэгдэж, 2024 онд 100 жилийн ойгоо угтаж байгаа түүхэн сум юм.



99920524



<http://zuunburen.se.gov.mn/>



Засаг захиргааны хувьд Жаргалант, Бэлчир, Мангирт гэсэн 3 багтай, 869 өрхийн 3057 хүн амтай, нийт 120949 га талбай нутаг дэвсгэртэй.

Улаанбаатар хотоос 344 км, аймгийн төвөөс 49 км, Дархан-Уул аймгаас 118 км зайд байрладаг. Олон улсын чанартай авто замаас салаалж Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар сумдыг холбосон улсын чанартай хатуу хучилттай асфальтан зам дайран өнгөрдөг, зам харилцаа хөгжсөн давуу талтай.



Төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдсон, 17 инженерийн болон гүн өрмийн худаг байдаг бөгөөд 3 худгийг жимс жимсгэнэ тарих, 1 худгийг ундны усны зориулалтаар, 12 худгийг бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар ашиглаж байна.

Монгол оронд ургадаг 600 орчим эмийн ургамлаас ихэнх нь Зүүнбүрэн сумын нутагт ургадаг, олон төрлийн эмийн нөөцтэй ба булга, дорго, бор гөрөөс, хярс, ангир, уулын үен, сойр, ятуу зэрэг нэн ховор ан амьтантай, байгалийн баялаг бүхий нутаг юм.

Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх аймгийн бодлого зорилгод нийцүүлэн орчин цагийн дэвшилтэд технологид суурилуулан мал аж ахуйг хөгжүүлэхийг зорин ажиллаж байна.

ТУС СУМЫН ХӨГЖИХ БОЛОМЖ?

Зүүнбүрэн сум нь мал аж ахуй, газар тариалан эрхлэхэд тохиромжтой.

Гадаргын болон завсарын ус ойр байдаг, уулын болон нутгийн хүрэн хөрс зонхилж байгаа нь төмс хүсний ногоо, усалгаатай тариалан, жимс жимсгэнэ тариалах таатай нөхцөл бүрдсэн.



Сүүлийн жилүүдэд хүнсний ногоо тариалалт нэмэгдэж жилдээ 350-420га талбайд тариалж 3800-4500 тн хүнсний ногоо хураан авдаг. Үүнээс сонгино, саримс, тарвас нь зах зээлд танигдсан. 2022 онд "Саримс" нь Сэлэнгэ аймгийн бренд бүтээгдэхүүнээр шалгарсан.



Мөн зөгийн аж ахуй эрхлэгчид жилээс жилд нэмэгдэж байна.

Аймаг, нийслэлтэй хатуу хучилттай замаар холбогдсон тул өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ногоог зах зээлд нийлүүлэх боломжтой.

Төмс хүсний ногоо, усалгаатай тариалан, жимс жимсгэнэ тариалах бүрэн боломжтой.



ХОТ ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БҮЙ БОЛОН ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ АЖИЛ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛ?

Тариалангийн үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин 2023 онд сумын хэмжээнд 2 зоорь ашиглалтад орсноор ногоочид тарьсан ногоогоо сумандаа хадгалж борлуулж байна.

Мөн малын үүлдэр угсааг сайжруулж эрчимжсэн, хагас эрчимжсэн, фермерийн аж ахуйг хөгжүүлэх бааз суурь нь тавигдсан.

Төрийн албанд тогтвор суурьшилтай ажиллах, нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор сумын төвд 16 айлын 4 блок орон сууцны барилга баригдаж байгаа ба 2023 оны 4-р улиралд эхний ээлжийн орон сууц ашиглалтад орно.

Төрийн албан хаагчид хөнгөлөлттэй ипотекийн зээлд хамрагдах боломжтой.